



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/118

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 45 дугаар сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 05 дугаар сарын 30-ний өдрийн 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 4,647,700.00 (дөрвөн сая зургаан зуун дөчин долоон мянга долоон зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн баланст шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг нийслэлийн ерөнхий боловсролын 45 дугаар сургууль (Ц.Пүрэвцэрэн)-д зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль (Б.Наранчимэг)-т даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГА



В.ОЮУМАА



Байгууллага:Балансаас шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага:Нийслэлийн ерөнхий боловсролын 45 дугаар сургууль

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага
1	Компьюер I MAC-215	2025	ш	1	3,350,000.00	45 дугаар сургууль	4 дүгээр сургууль
2	Зөөврийн компьютер Aser A3152582308R	2025	ш	1	1,297,700.00		
	Дүн			2	4,647,700.00		